

ОВООТЫН ЧУЛУУН НҮҮРСНИЙ ОРД ТӨСӨЛ БОЛОН,
НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨСЛҮҮДИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 2024

Байгальд ээлтэй

Орон нутагт өгөөжтэй



**ХУРГАТАЙ
ХАЙРХАН**

БАТЛАВ:

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:

..... (О.АМАРСАНАА)

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

ХУРГАТАЙ ХАЙРХАН ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



..... (ДАЧИТ-ЭРДЭНЭ)

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦЭЦЭРЛЭГ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ ОВООТЫН ЧУЛУУН
НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСӨЛ БОЛОН НҮҮРС БАЯЖУУЛАХ
ҮЙЛДВЭР ЗЭРЭГ ТӨСЛҮҮДИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР MV-017098/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР 5104424

ХЯНАСАН:

БОАЖЯ-НЫ ХБОБЗГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ:

..... /Ц.ЖАРГАЛНЭМЭХ /

БОЛОВСРУУЛСАН:

ХУРГАТАЙ ХАЙРХАН ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЭЛТСИЙН ДАРГА:

.....

A blue ink signature consisting of a large, stylized loop.

/ СЭМ БОУЛС /

АГУУЛГА

1	Төслийн товч танилцуулга	2
1.1	Төслийн ерөнхий төлөвлөгөө	2
1.2	Төслийн 2024 оны төлөвлөгөө, хамрах хүрээ	3
1.3	Төслийн талбай	3
2	Төслийн талбайн байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын хураангуй.....	4
2.1	Байгаль орчин.....	4
2.1.1	Уур амьсгал.....	4
2.1.2	Агаар орчин.....	4
2.1.3	Усан орчин.....	4
2.1.4	Газрын гадарга, хөрсөн бүрхэвч	5
2.1.5	Ургамлын нөмрөг	5
2.1.6	Амьтны аймаг.....	5
2.2	Нийгэм, эдийн засаг	5
2.2.1	Хөдөө аж ахуй.....	5
2.2.2	Уул уурхай.....	6
2.2.3	Бусад	6
3	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	7
3.1	Агаарт үзүүлж болзошгүй нөлөөлөл	7
3.2	Усанд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл	7
3.3	Ургамал, амьтанд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	7
3.4	Хөрс, газрын хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	7
3.5	Хог хаягдлын нөлөөлөл	7
4	2024 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ.....	8
5	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	9
6	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	10
7	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	10
8	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	10
9	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	10
10	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	11
11	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	11
12	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	12
13	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	13
14	Биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	13
15	Тэрбум мод хөтөлбөрийн мод тарих төлөвлөгөө	13
	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хавсралт	15
	ХАВСРАЛТ : Аж ахуйн нэгжийн гэрчилгээ.....	15
	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ.....	16
	Өмнөх онд ашиглалт эхлээгүй, үйл ажиллагаа явуулаагүй тухай тодорхойлолт	17
	2024 онд уулын ажлын төлөвлөгөөний Х тайлан илгээсэн цахим дэлгэцийн зураг	18

1 Төслийн товч танилцуулга

Төслийн нэр:	Овоотын коксжих нүүрс дараах төслүүдийг хамрана : (i) Овоотын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах; (ii) Овоотын ордыг түшиглэн барих нүүрс баяжуулах үйлдвэр (НБҮ) Дээрх хоёр төслийн бүтээн байгуулалт ашиглалтын MV-017098 тоот лицензийн зааг дотор явагдах бөгөөд бүтээн байгуулалтын ажил хараахан эхлээгүй байна.
Төсөл хэрэгжүүлэгч:	Хургатай хайрхан ХХК
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот-15170, Чингэлтэй дүүрэг-1-р хороо, Бага тойруу-17, Жи жи цамхаг 9-р давхар
Улсын бүртгэлийн дугаар:	9019053077
Регистрийн дугаар:	5104424

Овоотын нүүрсний уурхайн ашиглалтын MV-017098 тоот лицензийн талбайд явагдах чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн БОННУ 2022 оны 11 дүгээр сард батлагдсан. (Тайлангийн дугаар: 2019/Б-008)

Мөн Овоотын нүүрсний уурхайн ашиглалтын MV-017098 тоот лицензийн талбайд байгуулагдах Овоотын ордыг түшиглэн барих нүүрс баяжуулах үйлдвэр (НБҮ)-ийн БОННУ 2024 оны 4 дүгээр сард батлагдсан (Тайлангийн дугаар 20123/СН-42).

Энэхүү Овоотын коксжих нүүрсний төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Овоотын нүүрсний уурхай болон Овоотын нүүрс баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлагуудыг биелүүлэх зорилгоор бэлтгэсэн бөгөөд БОННУ тайлангуудад нийтлэг болзошгүй нөлөөлөл, мониторингийн арга хэмжээг тухайн оны сүүл үеэр батлагдсантай уялдуулан тодорхойлсон болно.

Уг байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дээрх батлагдсан БОННУ тайлангийн дагуу, Байгаль Орчин Аялал Жуулчлалын Сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлан компанийн тогтвортой хөгжлийн бодлогийг хэрэгжүүлэх, сум орон нутгийн холбогдох боловсон хүчин, эрх бүхий албан тушаалтнууд хоорондын ойлголцол холбоог хөгжүүлэх тус тус зорилготойгоор боловсруулав.

1.1 Төслийн ерөнхий төлөвлөгөө

Овоотын коксжих нүүрсний төсөл нь MV-017098 тоот ашиглалтын лицензийн талбайн хүрээнд жилд ойролцоогоор 1.5 сая тонн түүхий нүүрсийг ил уурхайн аргаар олборлож, уг нүүрсийг газар дээр нь боловсруулан 1.2 сая тонн орчим угаасан коксжих нүүрсийг борлуулахаар төлөвлөж байна.

Өмнөх төлөвлөсөн үйл ажиллагаандаа орон нутгийн иргэдээс ирүүлсэн санал хүсэлтүүдийг тусган компаний бодлого, журманд ихээхэн шинэчлэлт оруулсан. Төлөвлөсөн үйл ажиллагааны цар хүрээ өмнөхөөс багассан бөгөөд байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хязгаарлах үүднээс төлөвлөсөн ажлын систем болон туслах дэд бүтцийг шинэчилсэн.

Овоотын нүүрсний уурхай болон Овоотын нүүрс баяжуулах үйлдвэрийн барилга угсралтын ажлыг дэлхийн жишигт нийцүүлэн, Монгол Улсын хууль, тогтоомжийн шаардлагыг хангасахаас гадна илүү чанартай гүйцэтгэхээр төлөвлөж байна.


1.2 Төслийн 2024 оны төлөвлөгөө, хамрах хүрээ

Овоотын коксжих нүүрсний төсөл нь 2024 онд олборлолт, боловсруулалттай холбоотой ямар нэгэн барилга байгууламж, ашиглалтын ажил яваагүй бөгөөд 2024 ондоо ашиглалтад орохгүй байх төлөвтэй байна. MV-017098 ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд одоогоор зөвхөн жижиг хайгуулын кемп байгаа бөгөөд зөвхөн байгаль орчны хяналт, олон нийтийн харилцаатай холбоотой үйл ажиллагаа явуулж байна.

Хургатай хайрхан ХХК нь 2024 оны хугацаанд Овоотын коксжих нүүрсний төслийн бүтээн байгуулалттай холбоотой төлөвлөгөө, зөвшөөрлүүдийг (дагаолдах дэд бүтэцтэй холбоотой), төслийн бүтээнбайгуулалтыг дэмжих санхүүжилтийг босгох, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх боломжийг бүрдүүлэхийн тулд барилгын гэрээ хэлэлцээр хийхээр ажиллаж байна. Талбай дээрх барилгын ажил 2025 он хүртэл эхлэх боломжгүй.

1.3 Төслийн талбай

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн байршил нь Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын төв Халбан-аас урд зүгт 22 км, Могойн голын нүүрсний уурхайн зүүн талд (Зураг 1) байрладаг.



Зураг 1: Төслийн байршил

2 Төслийн талбайн байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын хураангуй

2.1 Байгаль орчин

2.1.1 Уур амьсгал

Төслийн талбай нь уур амьсгалын мужлалаар хангайн уулархаг бүсийн чийглэгдүү хүйтэвтэр зунтай, хахир хүйтэн өвөлтэй, хүйтэн салхи ихтэй мужид хамаарна. Нарны нийлбэр цацраг 1200 кВт цаг/м² буюу нийлбэр цацрагаар Монгол орны хамгийн бага бүсэд оршдог.

Цэцэрлэг сумын агаарын дундаж температурын хэлбэлзэл 38 жилийн дунджаар:

- хаврын улиралд -14.1°C-аас +6.6°C,
- зуны улиралд +6.6°C-аас +5.6°C,
- намрын улиралд +5.6°C-аас -16°C,
- өвлийн улиралд -16°C-аас -14.1°C.

Жилийн хамгийн дулаан сар нь VII сар бөгөөд 38 жилийн дунджаар VII сарын дундаж температур 14.6°C байна. Хамгийн хүйтэн сар нь I сар бөгөөд дунджаар -27.8°C байдаг байна.

Төслийн талбайн ойр орчмын сүүлийн 38 жилийн хур тунадасны нийлбэр дундаж үзүүлэлтээр:

- Дулааны саруудаас
 - хамгийн их хур тунадастай нь 7 сар, 69 мм хур тунадас орсон байсан бол
 - хамгийн бага хур тунадастай нь 5 сар, 13.5 мм хур тунадас орсон.
- Хүйтний саруудаас
 - хамгийн их хур тунадастай нь 10 сар,
 - хамгийн бага нь 1 сар байна.

Цэцэрлэг сумын хэмжээнд 1984-2021 оны хур тунадасны жилийн нийлбэрийн өөрчлөлт нь:

- 2002 онд бусад онуудаас бага хур тунадастай жил байж жилийн хур тунадасны нийлбэр 121.1 мм байсан байна.
- 2016 онд хамгийн их хур тунадастай, жилийн хур тунадасны нийлбэр 426.3 мм хүрсэн байна.

2.1.2 Агаар орчин

Төслийн талбай одоогийн байдлаар эзлүүд, агаарын чанар бага зэрэг хэлбэлзэлтэй байна. Учир нь төслийн талбайн баруун хойно байрлалтай Могойн голын уурхайгаас салхины аясаар тоосжилт үе үе ажиглагдана. Мөн тус Могойн голын уурхайн шороон замын дагуух машин тээврээс бага зэрэг тоосжилт ажиглагддаг байна.

2.1.3 Усан орчин

Төслийн талбайд гадаргын ус байхгүй. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газартай давхцалгүй юм. Монгол орны гидрогеологийн мужлалаар Увс нуурын районы түр зуурын элбэг тэжээгдэлтэй мужид багтах бөгөөд сав газрын хувьд Увс нуур, Тэсийн голын сав газарт багтдаг.

2.1.4 Газрын гадарга, хөрсөн бүрхэвч

Төслийн талбай нь тэгшивтэр болон нугачаат уудам хөндий, тал газрын хэв шинжтэй бөгөөд хөрс нь хөндийн шавранцар хүрэн хөрстэй, чулуурхаг хархүрэн хөрс зонхилно. Уг талбай нь анх 1984 онд атрын 2 дугаар аяны газар тариалангийн талбайн дунд оршино. Талбайн хөрсний үржил шимт байдал тухайн үеийн тариалалтын дараах зохих уриншуулалт, хамгаалалт хийгдээгүйгээс элэгдэлд орж, үржил шимээ алдсан бөгөөд атаржсан талбай юм.

2.1.5 Ургамлын нөмрөг

Төслийн талбайн ургамалжил нь уулын хээрийн ургамал зохилох бөгөөд атрын аяны хүрээнд бий болсон газар тариалангийн зориулалтаар ашиглаж байсан, атаршсан талбай байна. Талбайн ойр орчим 9 овгийн 19 зүйлийн ургамал зонхилон ургаж байна.

2.1.6 Амьтны аймаг

Төслийн талбай нь тал хээр нутагт хамаарах бөгөөд төслийн талбайд цайвар үлийч буюу үлийн цагаан оготно талбайн бүх хэсэгт их хэмжээний үлий үүсгэн тархсан нь түүгээр хооллон амьдардаг махчин шувууд болон мах идэшт жижиг амьтад элбэг байх нөхцөлийг бүрдүүлжээ. Төслийн талбай болон түүний орчимд тохиолдох боломжтой зүйлүүд нь нийт 5 баг, 10 овогт хамаарах 14 зүйлийн хөхтөн, 1 салбар баг, 2 овогт хамаарах 4 зүйлийн мөлхөгч, 1 баг, 1 овогт хамаарах 1 зүйл хоёр нутагтан, 5 багт хамаарах 16 зүйл шувууг хээрийн судалгааны явцад болон Бүс нутгийн улаан дансны цувралууд, Монгол орны хөхтөн амьтан таних гарын авлага (2014) зэрэг бүтээлийг шүүж тоймлон авч үзсэн.

2.2 Нийгэм, эдийн засаг

2.2.1 Хөдөө аж ахуй

Нутгийн иргэд уламжлалт бэлчээрийн мал аж ахуй голчлон эрхэлдэг ба газар тариалан эрхэлдэггүй байна. 1980-аад оны атрын аяны хүрээнд хагалж байсан атаржсан талбай тус газарт үлдсэн бөгөөд уг талбай нь түүнээс хойш ашиглагдахгүйгээр атаршиж, байгалийн үндсэн хэв шинжээ алдсан байна. Энэхүү атаржсан талбай нь Хургатай хайрхан ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайн 1000 орчим га талбайг эзэлдэг.

Бид тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд орон нутгийн мал аж ахуйг дэмжиж, тухайн ашиглагдахгүй атаржсан талбайн зарим хэсгийг дахин ашиглаж, төслийн талбайгаас зүүн тийш бага хэмжээний талбайд (200 га) ногоон тэжээл тариалах, хураах ажлыг амжилттай хэрэгжүүлж, орон нутгийн иргэдэд ногоон тэжээл тарьж болохийг харуулахын зэрэгцээ, сонирхсон иргэдэд зааж сурган, амьжиргаанд нь багахан ч гэсэн хувь нэмрээ оруулсаар байна.



Мөн орон нутгаас худалдан авах боломжит бараа бүтээгдэхүүнээ худалдан авдаг бөгөөд, тэр дундаа мах, сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэх чиглэлд хамтран ажилладаг.

2.2.2 Уул уурхай

Төслийн талбайн баруун талд, залган “Могойн гол” ХК-ний нүүрсний уурхай байрладаг бөгөөд үйл ажиллагаагаа 1971 оноос хойш явуулж байна. Монгол улсын Засгийн газрын өмч хувьчлалын комиссын 1994 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 35 дугаар тогтоолоор төрийн өмч давамгайлсан “Могойн гол” хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулагдан үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна.

2.2.3 Бусад

Цэцэрлэг сум нь Монгол орны баруун хойд хилийн бүсэд, Орос улстай хиллэдэг бөгөөд Улаанбаатар хотоос хамгийн алслагдсан сумдын нэг юм. Энэ суманд дэд бүтэц, зам харилцаа муу хөгжсөн, үйлчилгээ, үйлдвэржилтийн салбар хараахан хөгжөөгүй, хөдөлмөр эрхлэлт, ажлын байр дутмаг газар байдаг.

3 Гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Одоогоор төслийн талбайд аливаа барилга байгууламжийн ажил эхлээгүй байгаа бөгөөд тус 2024 онд үйл ажиллагаа явуулахгүй юм. Харин төслийн талбайд үйл ажиллагааг эхлэхээс өмнөх бэлтгэл ажил, түр ажилчдын байрлуулах түр кемп буюу 8ш гэр бэлэн байрлуулсан.

3.1 Агаарт үзүүлж болзошгүй нөлөөлөл

Агаарын чанарт нөлөөлж болзошгүй дараах нөлөөллүүд байна. Үүнд:

- Овоотын түр кемпийн гэрт галлагаанаас бага хэмжээний тоосжилт үүсэх.

3.2 Усанд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Гадаргын ба газрын доорхи усанд үзүүлж болзошгүй дараах сөрөг нөлөөллүүд байна. Үүнд:

- Кемпийн үйл ажиллагаанаас газрын гадарга болон гүний усанд сөрөг нөлөөлөл үүсгэхгүй.

3.3 Ургамал, амьтанд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Ургамал, амьтанд үзүүлж болзошгүй дараах сөрөг нөлөөллүүд байна. Үүнд:

- Түр кемпийн үйл ажиллагаанаас орчны ургамал амьтанд сөрөг нөлөөлөл үүсгэхгүй.

3.4 Хөрс, газрын хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Хөрс, газрын хэвлийд үзүүлж болзошгүй дараах сөрөг нөлөөллүүд байна. Үүнд:

- Төслийн үйл ажиллагаа эхлээгүй, газар хөндөхгүй тул хөрс газрын хэвлийд сөрөг нөлөөлөл үүсэхгүй.
- Автомашины тос тосолгооны материалын асгаралт бага зэрэг гарч болзошгүй тул асгаралтаас сэргийлэх арга хэмжээ авах

3.5 Хог хаягдлын нөлөөлөл

Дараах хог хаягдал үүснэ:

- Кемпийн үйл ажиллагаанаас бага хэмжээний шингэн хаягдал үүснэ (саарал ус, бохир ус г.м)
- Кемпийн үйл ажиллагаанаас ахуйн хатуу хог хаягдал үүснэ (хоолны хаягдал, сав баглаа, г.м)

4 2024 оны байгаль орчныг хамгаалах ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Байгаль Орчин Аялал Жуулчлалын Сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-д заагдсан бүтэц, агуулга, аргачлалын дагуу боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөний гол зорилго нь үйл ажиллагааны өмнөх байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах суурь бэлтгэлтийг хангах, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг олж илрүүлэх, сөрөг үр дагавар байгаа бол түүнээс урьдчилан сэргийлэх, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд үр дүнтэй байгаа эсэхийг тогтооход оршино.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нийт зардал **25,323,050** төгрөг болох бөгөөд зардлын хураангуйг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1. Байгаль орчны хамгаалах төлөвлөгөөний зардлын хураангуй / төгрөг /

Бүлгийн №	Хамгааллын арга хэмжээ	Нийт
5	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	400,000
6	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	0
7	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах	0
8	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	0
9	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	0
10	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	250,000
11	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2,050,000
12	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2,550,000
13	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	10,000,000
14	Биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	0
15	Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд мод тарих төлөвлөгөө	9,623,000
Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нийт зардал		24,873,000

5 Сөрөг нөллөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Агаарын чанар	Төслийн баяжуулах үйлдвэрийн онцлогт тохируулан сэргээгдэх эрчим хүчийг цахилгаан хангамжид ашиглах боломж бололцоог судлах, нэвтрүүлэх	Мониторингийн хяналтын цэгүүдэд	удаа	Хяналт мониторингийн хэсэгт тусгав	3	-	2024 онд	Агаарын тухай хууль Дотоод журам
		Агаарын чанарын дотоод бодлого, журмыг боловсруулах	Баяжуулах үйлдвэрийн талбай	удаа	Байгаль орчны дотоод журамаар зохицуулагдана	1	-	2024 онд	
2	Гадаргын ба газрын доорхи усны нөөц	Түр кемпийн үйл ажиллагаанд усны зөв зохистой, үр ашигтай хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор кемпийн дотоод жураманд байгаль орчны журмыг оруулах.	Түр кемп, талбай	Удаа	Байгаль орчны дотоод журамаар зохицуулагдана	Тогтмол	-	Тогтмол	MNS 900:2010 MNS 4943:2011 MNS 5668:2006
		Зөвшөөрөгдсөн ашиглах усны эх үүсвэрт зуны дулаан улиралд усны тоолуур суурилуулж, ашиглалтын зохимжтой инженерчлэл, зураглалын дагуу, өвлийн цагт битүүмжлэл хийж, тогтмол арчилгаагаар хангах	Зөвшөөрөгдсөн усны эх үүсвэр	Удаа	200,000	Тогтмол	200,000	2024 онд	Усны тухай хууль 30.1.4
		Ашиглах усны хэмжээг нарийн тооцож, ашиглах усны төлбөрийг орон нутгийн холбогдох байгууллагын дансанд төвлөрүүлнэ	Зөвшөөрөгдсөн усны эх үүсвэр	ш	200,000	-	200,000	2024 онд	МУ 3Г тогтоол № 326 Усны нөөц ашигласны төлбөр
3	Хөрсөн бүрхэвч	Овоотын түр кемпд ирж очих автомашины хөдөлгөөнийг тогтмол маршрутаар зохицуулах журам боловсруулах	Кемп	Удаа	Байгаль орчны дотоод журамаар зохицуулагдана	Тогтмол	-	Тогтмол	MNS 5916:2008 MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
		Хөрс саармагжуулах талбай байгуулах	Кемп	Ш	-	-	-	-	
		Шаардлагагүй газар хөндөхөөс сэргийлэх, шимт хөрсний овоолго, газар хөндөх журам зэргийг боловсруулж хэрэгжүүлэх	Кемп	ш	Дотоод зардалд	1	Дотоод зардалд	Дотоод зардалд	
Нийт					400,000				

6 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

2024 онд барилга байгууламжийн ажил хийгдэхгүй бөгөөд аливаа газар хөндөх үйл ажиллагаа талбайн хүрээнд хийгдэхгүй. Дотоод газар хөндөх, нөхөн сэргээх журам боловсруулж, дагаж мөрднө.

7 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Тайлант онд барилга байгууламжийн ажил хийгдэхгүй бөгөөд аливаа газар хөндөх үйл ажиллагаа талбайн хүрээнд хийгдэхгүй.

8 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн барилга байгууламжийн үйл ажиллагаа 2024 онд явагдахгүй ба аливаа сөрөг нөлөөлөл үүсэхгүй. Мөн орон нутгийн нөлөөллийн бүсийн айлуудтай холбоо харилцаагаа хэвийн үргэлжлүүлнэ.

9 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Археологи, палеонтологийн судалгааны ажлын 2011, 2012 онд хийгдсэн тайлангийн үр дүнд төслийн талбайд соёлын ач холбогдол бүхий зүйл илрээгүй.

Ажилчидад соёлын өвийн таларх мэдлэг олгох зааварчилгаанаас гадна боломжит олдворыг хэрвээ олж илрүүлсэн тохиолдолд хамгаалах арга хэмжээ авах юм.

№	Нөлөөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төг)	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Археологийн дурсгал	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн заалт, шаардлагуудыг хэрхэн биелүүлэх талаар ажилчдад зааварчилгаа өгөх	Компанийн ажилчид, гэрээт ажилчид	1	1	-	Дотоод үйл ажиллагааны зардалд тусгасан	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 23.1 Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тушаал № 141
2	Палеонтологийн дурсгал							
	Нийт					-	0	



10 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Төслийн үндсэн үйл ажиллагаа барилга байгууламжийн ажил хийгдэхгүй бөгөөд аливаа үйл ажиллагаа талбайн хүрээнд хийгдэхгүй.

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Гал түймрийн аюул эрсдэл	Хайгуулын түр кэмпэд байгаа галын пунктийг сэлбэн бүрэн бүтэн байдлыг хангах	кэмп	1	250,000	250,000	2024	Галын аюулгүй байдлын тухай хууль
	Нийт					250,000		

11 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас гарах бүхий л хог хаягдлуудыг Овоотын уурхайн одоогийн түр кемпийн үйл ажиллагааны хүрээнд ангилан ялгаж, хог хаягдлыг аль болох хамгийн бага гаргах, үүссэн хог хаягдлыг дахин боловсруулах оновчтой шийдлийг хэрэгжүүлэх, дахин шууд ашиглах зэргээр хог хаягдлын менежмент төлөвлөгөөний дагуу шийднэ. Харин Баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжийн ажил хийгдэхгүй бөгөөд аливаа үйл ажиллагаа талбайн хүрээнд хийгдэхгүй.

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгж зардал (төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.	Түр кемп	Дотоод зардалаар		1	0	2024 онд	Хог хаягдлын тухай хууль
		Цэцэрлэг сумын ЗДТГ-аас хог хаягдлын гэрээ байгуулж, уурхайн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг булж зайлуулах ландфилл цэг тогтоож зөвшөөрөл авсан байна.	Түр кемп	удаа	50,000	1	50,000	2024 онд	Хог хаягдлын тухай хууль
1	Ахуйн	Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин ашиглах боломжтой хаягдлыг боловсруулах, дахин ашиглах боломжгүй хог хаягдлыг тогтоосон хугацаанд зохих журмын дагуу тээвэрлэх ажлыг хэрэгжүүлж ажиллана. Ажилчид болон гэрээт гүйцэтгэгчид хог хаягдлын зааварчилгаанд хамруулна	түр кемп	БОХТ-ийн зааварчилгаатай хамтатган зохион байгуулах тул нэмэлт зардал гарахгүй				2024	Хог хаягдлын тухай хууль 2017-05-12 Шинэчилсэн найруулга
		Ажилчдын кэмпэд ангилан ялгах цэгийг шинэчлэн засварлаж, хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж, тэмдэгжүүлэх	түр кемп	удаа	2,050,000	1	2,050,000	2024 онд	

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгж зардал (төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		Хог хаягдлын менежмент, талбайн үзлэгийг өдөр тутамд зохион байгуулж хяналт тавих	түр кемп						
3	Аюултай	Төслийн талбайд аливаа аюултай химийн бодис ашиглахгүй	түр кемп	-	-	-	-	-	
	Нийт						2,050,000		

12 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь БОННУ 4-р сард батлагдсанай холбоотойгоор тухайн жилийн дунд үеэс батлуулж байгаа тул тухайн оны 12 сарын 31-нээс өмнөх боломжит хугацаа ба давтамжийг төлөвлөж тусгасан болно.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1	Агаарын чанар							
	Агаарын чанар, дуу чимээний дотоод шинжилгээ	Агаарын чанарын Хяналтын цэг	удаа	2	250,000	750,000	Хяналт шинжилгээний байнгын хэмжилт, судалгаа	Агаарын тухай хууль MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
	PM2.5, PM10, TSD, SO2, NO2,		удаа	2	150,000	450,000	Итгэмжлэгдсэн лабораториор хийлгэх	
	Агаарын чанарын хөндлөнгийн шинжилгээ		удаа	1	Д3	Д3	-	
2	Хөрсөн бүрхэвч							
	Хөрсний чанарын шинжилгээ Хөрсний элэгдэл эвдрэлийн нөхцөл, ялзмаг %, рН, давсжилт, чийгшилт, физик химийн шинж чанар, органик бодис, нийт азот, карбонат, Са, Mg, P2O5, K2O, хүнд металлын үзүүлэлтүүд	Хөрсний чанарын хяналтын цэг	ш	1	450,000	450,000	Итгэмжлэгдсэн лабораториор хийлгэх	MNS 5850: 2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ.
3	Усны чанар							
	Усны физик химийн шинж чанарын дэлгэрэнгүй шинжилгээ, хүнд металлын бохирдлын шинжилгээ хийх: Pb, Cr, Cd, Zn, Ni, Cu	Усны чанарын хяналтын цэгүүд	ш	2	450,000	900,000	Итгэмжлэгдсэн лабораториор хийлгэх	MNS0900:2016 хүрээлэн буй орчин.
	Нийт					2,550,000		

Д3-Дотоод зардал

13 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хугацаа	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			9 Сар		
1.	Байгаль орчны аудит хийлгэх	10,000,000	1	Байгаль орчны хэлтэс	Байгаль орчны тараарх хэтийн үүсэх эрсдлийг олж илрүүлэх, бууруулах, арилгах арга хэмжээ
	Нийт	10,000,000			

14 Биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад дараах байдлаар тайлагнаж, танилцуулга хийхээр төлөвлөж байна:

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал (төг)	Хариуцсан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1	Нөлөөллийн бүсийн айлууд	Биеэр болон цахим танилцуулна	Байгаль орчны арга хэмжээ Ажлын гүйцэтгэл	2024	Дотоод зардлаар	Компанийн орон нутгийн мэдээллийн ажилтан	Нөлөөллийн бүсийн айлууд
2	Орон нутгийн засаг захиргаа	Биеэр болон цахим танилцуулна	Ажлын гүйцэтгэл	2024	Дотоод зардлаар	Компанийн орон нутгийн мэдээллийн ажилтан	Сумын захиргаа
	Нийт				Дотоод зардлаар		

15 Тэрбум мод хөтөлбөрийн мод тарих төлөвлөгөө

“Хургатай хайрхан” ХХК “Тэрбум мод” аяныг дэмжин 10 сая мод тарих үүрэг хүлээж, энэхүү амлалтаа биелүүлэх зорилгоор төслийн харьяалагдах Хөвсгөл аймгийн Цэцэрлэг суманд мод үржүүлгийн газар байгуулж, үрээр болон харандаан суулгацаар төрөл бүрийн мод тарих туршилт хийж, шилжүүлэн суулгах суулгацыг үйлдвэрлэж байна. Энэхүү мод үржүүлгийн газарт 10 сая модны суулгацийг тарьж, бэлтгэх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд тарьсан моддыг Овоотын коксжих нүүрсний төслийн лицензийн талбайн ногоон байгууламж, нөхөн сэргээлтийн дараах талбайд болон төлөвлөж буй Төслийн талбайгаас Эрдэнэт хотын төмөр замын дэд бүтцийн байгууламж хүртэлх замын барилга байгууламж дагуу тарьж ургуулах зорилготой юм. Үүнд тус төслийн талбайнуудын хооронд баригдах бусад компаниудын дэд бүтцийн талбай ч мөн хамрагдах юм.

Түүнчлэн манай компани бүс нутгийн мод тарих ажлыг дэмжих чиглэлээр орон нутгийн засаг захиргааны байгууллага, БОАЖЯ-тай нягт хамтран ажиллах хүсэлтэй байна.

Манай мод үржүүлгийн талбай нь үйл ажиллагааны цар хүрээний хувьд жижиг ба олон зүйлийн мод үржүүлэг, тарьц суулгацуудыг тарьж ургуулах туршилт судалгааны талбай бөгөөд цаашид тухайн жилийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн өмнөх туршилтийн тарьц суулгацийн талбай болно.

Мөн эргэн тойронд тариалах төслийн төлөвлөгөөнд тусгагдсан дэд бүтцүүдийн томоохон талбайнууд шилжүүлэн суулгахад хараахан бэлэн болоогүй байгаа тул ойрын хэдэн жил том хэмжээний суулгац тариалах төлөвгүй байна.

Манай мод үржүүлгийн газарт 2023 оны намрын тооллогоор 5659 ширхэг суулгац ургаж байна.

Хүснэгт 2. Мод үржүүлгийн талбайд ургаж буй тарьц суулгац

№	Нэр	Латин нэршил	Ургаж буй орчин	Өндөр (см)	Нас (жил)	2023 оны намрын тоо (ш)
Үрээр						
1	Чацаргана		Хүлэмж	30-40	2	539
2	Агч	Acer ginnala	Хүлэмж	30-70	2	302
3	Нарс	Pinus pumila	Хүлэмж	4 - 5	2	80
4	Хайлаас	Ulmus pumila	Ил талбай	5 - 30	2	2,800
5	Шар хуайс	Caragana arborescens	Ил талбай	8 -50	2	938
Харандаан тарьц						
1	Улиас	Larix sibirica Ledeb	Ил талбай	150-180	2	240
2	Бургас		Ил талбай	150-180	2	760
					Нийт	5,659

2024 онд ойролцоогоор 1000 гаруй суулгацийг шилжүүлэн суулгахаар төлөвлөн. Үүний ихэнхийг нь Ашиглалтын лицензийн талбай дах Компанийн хайгуулын кемпийн хашаатай талбайд тарина. Тус кемпийн салхин хамгаалалт болон өнгө чимэглэлийн зориулалтаар таригдах бөгөөд кемпийн ажилчид арчилгаа, усалгааг хийх боломж бүрдэх юм.

Хүснэгт 3. Шилжүүлэн суулгах модны мэдээлэл

№	Тарьц	Өндөр, см	Нас, жил	2023 оны намрын тоо (ш)	2024 онд тарих тоо (ш)
1	Улиас	150-180	2	240	240
2	Бургас	150-180	2	760	760
				1,000	1,000

Түүнчлэн мод үржүүлгийн талбайгаас өөрсдийн тарьж ургуулсан моддоос Мөрөн хот болон Цэцэрлэг сумын Засаг даргын тамгын газарын хүсэлтээр 200 орчим модоор хангах ажлыг зохион байгуулна.

2024 оны мод тарих ажлын төсөв

Материал	Нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
Мод шилжүүлэн суулгах ажил гүйцэтгэх	ш	1000	9000	9,000,000
Түлш				
Хөрс, бууц зөөврийн ачаатай машин	л	21.6	4,250	91,800
Хөрс зөөлрүүлж, татах унагалдай	л	50.0	4,250	212,500
Нүх ухах трактор	л	65.0	4,250	276,250
Усны машин	л/өдөр	10	4,250	42,500
Кемпийн зардал				
Сумын төвд - хүнс	Өдрийн хүнс	20	Д3	Д3
Кемпд хүнс	Өдөр	60	Д3	Д3
Тогооч	Өдөр	10	Д3	Д3
Цэвэрлэгч	Өдөр	10	Д3	Д3
Нийт зардал				9,623,050

Д3 – Дотоод зардал

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хавсралт

ХАВСРАЛТ : Аж ахуйн нэгжийн гэрчилгээ

УБ-2 Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.

**МОНГОЛ УЛС**
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
0000093467

2006.12.21 9019053077
/ Бүртгэсэн он, сар, өдөр / */ Улсын бүртгэлийн дугаар /*

5104424
/ Регистрийн дугаар /

Хургатайхайрхан Гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал
хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, харилцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсэн байгуулах баримт бичиг /

Тушаал <i>/ шийдвэрийн нэр /</i>	А-2488 <i>/ дугаар /</i>	2006.12.21 <i>/ он, сар, өдөр /</i>
-------------------------------------	-----------------------------	----------------------------------------

4610 Гадаад худалдаа
/ код / */ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /*

0899 Ашигт малтмалын ашиглалт 2042.08.10 хүртэл
7490 Ашигт малтмалын хайгуул хийх /2009.03.16-2016.03.16/

/ код / */ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /*

15.07.06~17.07.06 <i>/ хугацаа /</i>	1 <i>/ гишүүдийн тоо /</i>	424,541.50 <i>/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /</i>
-----------------------------------------	-------------------------------	--------------------------------------------------------------------

Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, чингисийн ергэн чөлөө, Алтай цамхаг 3-р давхарг 302, Утас1: 70116828,
Утас2: 70116826, Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Улсын бүртгэлийн ерөнхий
газрын бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ бөхин олгосон 2015 он 5 сар 4 өдөр


ФА046: 5298723

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ



АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар *MV-017098*

Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн

_____ *Хөвсгөл* _____ аймаг /хот/-ийн
_____ *Цэцэрлэг* _____ сум /дүүрэг/-ын
_____ *Овоот* _____ нэртэй газарт орших
_____ *5758.70* _____ гектар талбай бүхий уурхайн талбайд
хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг
зөвшөөрч улсын бүртгэлийн _____ *9019053077* _____ тоот гэрчилгээтэй
_____ *“Хургатайхайрхан” ХХК* _____ *1620* _____ д
энэхүү тусгай зөвшөөрлийг _____ *2042.08.10* _____ дуустал
хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хуийнгүй.

ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН КАДАСТРЫН
ХЭЛТСИЙН ДАРГА _____ М.ЭНХТУЛГА

_____ *2012 оны 8 сарын 10 өдөр*
_____ Улаанбаатар хот

Өмнөх онд ашиглалт эхлээгүй, үйл ажиллагаа явуулаагүй тухай тодорхойлолт



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГА

Цэцэрлэг сум, Хөвсгөл аймаг, 67320
Цахим шуудан: Tsetserlegzdtg@khs.gov.mn
Цахим хуудас: <http://tsetserleg.khs.gov.mn>

2023. 12. 01 № 1/2021
танай 2023. 11. 02 -ны № 095 -Т

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, АУДИТЫН ХЭЛТЭСТ

Тус сумын Ренчинжугнай багийн нутагт орших
"Хургатай хайрхан" ХХК нь 2023 онд ашигт малтмал
олборлох үйл ажиллагаа явуулаагүй нь үнэн болно.

ДАРГА /  Н.АНХБАЯР



673203388



2024 онд уулын ажлын төлөвлөгөөний X тайлан илгээсэн цахим дэлгэцийн зураг

The screenshot shows a web browser window displaying a table of work plans. The browser address bar shows 'gms.mppam.gov.mn/#com/4002/'. The page title is 'Төлөвлөгөө, тайлангийн явц'. The table has the following columns: ID, Тэрийн дугаар, Хэлтэс, Тайлан / Төлөвлөгөө, Нэмэлт ТЭ-н дугаар, Тайлангийн огноо, Төлөв, Үе шат, Илгээсэн огноо, and Анх илгээсэн огноо. The first row is highlighted in pink and contains the following data: ID: 1, Тэрийн дугаар: 17098, Хэлтэс: Уул уурхайн хэлтэс (нурс), Тайлан / Төлөвлөгөө: Төлөвлөгөө, Нэмэлт ТЭ-н дугаар: -, Тайлангийн огноо: 2024, Төлөв: үргэлжлэх, Үе шат: Хүлээн Авах Хэсэг, Илгээсэн огноо: 2023-11-23 11:23:39, and Анх илгээсэн огноо: 2023-11-23 11:23:39. The table also has a search bar and a 'Хайх' button.

ID	Тэрийн дугаар	Хэлтэс	Тайлан / Төлөвлөгөө	Нэмэлт ТЭ-н дугаар	Тайлангийн огноо	Төлөв	Үе шат	Илгээсэн огноо	Анх илгээсэн огноо
1	17098	Уул уурхайн хэлтэс (нурс)	Төлөвлөгөө	-	2024	үргэлжлэх	Хүлээн Авах Хэсэг	2023-11-23 11:23:39	2023-11-23 11:23:39